



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар

А/12

Мандалговь

Г.Оюунтунгалагийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Гончигсамбуу овогтой Оюунтунгалаг 57.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Г.Оюунтунгалагийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн
асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн Г.Оюунтунгалагийн тухай дүгнэлт**

1. Г.Оюунтунгалаг нь 1980 онд Дундговь аймгийн Хулд суманд төрсөн. 43 настай, эмэгтэй
2. Боловсрол: 1999-2003 онд Монгол хэл бичгийн дээд сургуулийг багш орчуулагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг хэл шинжлэлээр магистр зэрэгтэй тус тус төгссөн.
3. 2001-2003 онд аймгийн НДХ-т эрүүл мэндийн даатгалын оператор, 2003-2012 онд Хүүхдийн төлөө хэлтэст хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан арга зүйч, хүүхдийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн, 2012-2016 онд аймгийн ЗДТГ-т нийгмийн хамгаалал хариуцсан мэргэжилтэн, 2021 оноос олон нийттэй харилцах ажилтнаар ажиллаж байна.
4. Г.Оюунтунгалагийн төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ